

ОЛОН УЛСЫН ТЕНДЕРТ ОРОЛЦОХ СОНИРХЛОО ИЛЭРХИЙЛЭХ УРИЛГА

("ЕРС" тендер шалгаруулалтын нэгдүгээр үе шат)

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТОД ИХ БАГТААМЖИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ "МЕТРО" БАРЬЖ БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

Сонирхлоо илэрхийлэх урилга НХААГ/20240101236

Огноо: 2024 оны 10 дугаар сарын 03

1. Танилцуулга

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (цаашид "Захиалагч" гэх) олон улсын туршлагатай аж ахуйн нэгж, түншлэлийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод баригдахаар төлөвлөгдөж байгаа их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" төслийн Зураг төсөл, Худалдан авах ажиллагаа, Барилга угсралтын "ЕРС" гэрээ байгуулах олон улсын тендерийн урьдчилсан сонгон шалгаруулалтад оролцож, сонирхлоо илэрхийлэх хүсэлтээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү өөрчлөн байгуулалтын төсөл нь хүн амын нягтаршил ихтэй хотод нийтийн тээврийг төрөлжүүлэн хөгжүүлэх болон орчин үеийн шийдэл бүхий нийгэм, эдийн засгийн үр ашигтай метрог барьж байгуулан хотын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой.

2. Сонирхлоо илэрхийлэх урилгын үндсэн зорилго

Сонирхлоо илэрхийлэх урилгын зорилго нь "Улаанбаатар Метро" төслийг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулахад оршино. Үүнд:

- Туршлагатай оролцогч нарыг тодорхойлох болон тэдний оролцоог хангах:** Метроны томоохон төслүүдийг төлөвлөх, барьж байгуулах, төслийг хэрэгжүүлэх туршлагатай олон улсын болон дотоодын тэргүүлэгч аж ахуйн нэгж болон тэдгээрийн түншлэлийг энэхүү тендерт идэвхтэй урьж оролцуулна.
- Ил тод байдал, шударга өрсөлдөөнийг дэмжих:** "Улаанбаатар Метро" төслийн хамрах цар хүрээ, техникийн шаардлага, үнэлгээний шалгуур, тендерийн материал ирүүлэх удирдамж зэрэг мэдээллийг тодорхой, цогц, хялбар, хүртээмжтэй байдлаар олон нийтэд нээлттэй хүргүүлэх замаар сонирхогч бүх талуудад ижил тэгш нөхцөлийг бүрдүүлнэ.

Тендерт оролцогчдын сонирхлоо илэрхийлэх үйл явцыг аль болох ил тод, няхуур хялбар байдлаар зохион байгуулж, Улаанбаатар хотын иргэдэд чанартай, аюулгүй ажиллагааг хангасан, нийгэм, эдийн засгийн үр ашигтай метроны системийг барьж байгуулах өндөр чадвартай, арвин туршлагатай, үүрэг хариуцлагатай аж ахуйн нэгж болон тэдгээрийн түншлэлийг татан оролцуулах нь Захиалагчийн үндсэн зорилго болно.

3. Тендерт оролцогчдын зүгээс анхаарах зүйлс:

Энэхүү сонирхлоо илэрхийлэх урилга нь (Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн сонгон шалгаруулалтын эхний үе шат гэсэн хэсэгт заасны дагуу) "Улаанбаатар метро" төслийг цаашид хөгжүүлэхэд чухал бэлтгэл үе шат болно. Тиймээс дараах чухал асуудлуудыг анхааралтай харгалзан үзнэ үү.

Техник Эдийн Засгийн Үндэслэлийн үнэлгээ (ТЭЗҮ) ба Дизайны шинэчлэл:

Шинэчлэгдэн боловсруулагдаж байгаа ТЭЗҮ:

Духуа Инженеринг зөвлөх компани нь 2024 оны 07 дугаар сараас хойш Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар ЖАЙКА-ын 2013 онд боловсруулсан метроны ТЭЗҮ-д иж бүрэн хяналт, шинжилгээ үнэлгээг хийж, шинэчлэн боловсруулах ажлыг хэрэгжүүлэх явцад ажиллаж байна. Тус шинэчлэгдсэн ТЭЗҮ нь өнөөгийн бодит нөхцөл байдал, дата судалгаа, өгөгдлийг нэгтгэж шинэчлэн боловсруулах нь энэхүү төслийг тууштай урагшлуулах тулгуур бааз суурь болно. “Улаанбаатар метро”-ны инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулахдаа шинэчилсэн ТЭЗҮ-с холбогдох мэдээллийг авах боломжтой.

Инженер геологийн болон байгаль орчны бүх төрлийн судалгааг шинэчлэн боловсруулсан ТЭЗҮ нь одоогийн нөхцөл байдал хувьд төслийн үр ашигтай байдлын талаар цогц үнэлгээг хийх, төслийн хамрах цар хүрээ болон төсөл хэрэгжих боломжит цаг хугацаа, төслийн төсөвт өртөг зэргийг үндэслэлтэйгээр дахин тооцоолж тодорхойлох зорилгын хүрээнд өөрчлөлт хийх шаардлага гарч болзошгүй.

- **Судалгааны үйл явц:** Тендерт оролцогч нарт ТЭЗҮ-ийн шинэчлэлтийн ажлын үйл явц болон төслийн шалгуур үзүүлэлтэд хэрхэн нөлөөлөл үзүүлэхийг харгалзан үзэхийг зөвлөж байна. Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл төрийн худалдан авах ажиллагааны портал дээрх "Өмнөх судалгааны тойм" явцын талаар мэдээллийг дараах линкээс үзнэ үү. <https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1726456870665>
- **Хууль эрх зүйн орчин:** Энэхүү сонирхлоо илэрхийлэх тендер шалгаруулалтын нэг дүгээр үе шат нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай Монгол Улсын хууль", Монгол Улсын Сангийн яамнаас гаргасан холбогдох журам болон Нийслэл Улаанбаатар хотын төсөвтэй холбоотой бусад бичиг баримтууд дээр үндэслэсэн.
- **Төслийн үр дүн:** Хэдийгээр төслийн сайжруулалт нь шинэчилсэн ТЭЗҮ дээр тулгуурлах боловч “Улаанбаатар Метро” төслийн явцад дараах үндсэн үр дүнгүүд гарах төлөвтэй байна.
 - Улаанбаатар хотын анхны метроны шугам ашиглалтад орсноор хотын нийтийн тээврийн системийг оновчтойгоор төрөлжүүлэн хөгжүүлж тэдгээрийг хооронд нь холбох боломж бүрдэнэ.
 - Метроны зарим нэг буудал/өртөөг “тээвэрлэлтэд суурилсан хөгжил”-ийн зарчим дээр үндэслэн барьж байгуулсны үр дүнд нийтийн тээврээр холбогдсон дэд төвүүдийн хөгжлийг дэмжих, метрог дагасан нийгэм, эдийн засгийн эерэг нөлөөллийг нэмэгдүүлнэ.
 - Метро нь урт хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй болон тогтвортой үргэлжлүүлэх нөхцөлийг хангахын зорилгын хүрээнд оновчтой үйл ажиллагаа, засвар үйлчилгээгээ үзүүлэх, шинэ “ноу-хау” мэдлэг, ажлын дүрэм, журам, норм, стандарт зэргийг нутагшуулах шаардлагатай болно.
- **Мэдээллийн авах:** Техникийн нөхцөл, ажлын даалгавар, нэмэлт тодруулга зэрэг холбогдох бүх баримт бичгийг төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn порталаас авах боломжтой. (<https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1726456870665>)

Анхаарах зүйлс: Духуа инженеринг зөвлөх компанийн хийж гүйцэтгэж буй ТЭЗҮ, зураг төсөл шинэчлэн боловсруулах хуваарийг энд хавсаргав. Төслийн цаг хугацааны гүйцэтгэлийн талаар хүснэгтэн мэдээлэл лавлагааг энд хавсаргасан. Тендер шалгаруулалтад оролцогчид сонирхлоо илэрхийлсэн хүсэлт ирүүлэхдээ энэхүү хуваарийн цаг хугацааг сайтар харгалзан үзэх хэрэгтэй.

Сонирхсон бүх этгээд буюу олон улсын туршлага бүхий аж ахуйн нэгж, түншлэлийг энэхүү тендерийн өмнөх үе шатад сонирхлоо илэрхийлэх үйл явцад идэвхтэй оролцож, “Улаанбаатар Метро” төслийг амжилттай хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулахыг Захиалагчийн зүгээс уриалж байна.

4. “ЕРС”-ийн тендерт шалгаруулалтад оролцогчдын төслийн цар хүрээ¹

Энэ хэсэгт “Улаанбаатар метро” төслийн тендерт оролцогчдын хийж гүйцэтгэх ажлын цар хүрээг нарийвчлан тусгасан болно. Тендерт шалгарсан оролцогч нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдийн зураг төсөл, худалдан авалт, барилга угсралт, ашиглалтад оруулах ажлыг хариуцна.

(а) Барилга угсралт, архитектур, цахилгаан ба механикийн ажил:

Энэхүү хамрах ажлын цар хүрээнд нарийвчилсан зураг дизайн болон түүний гүйцэтгэл багтсан :

- Хонгилын ажил: “Shield TBM” аргыг ашиглан 6.7-7.2 метрийн диаметртэй ойролцоогоор 6 километр хонгил ухах ажил. (ЖАЙКА, 2013)

-Шугамын дагуу хийгдэх байгууламжууд: Үүнд төмөр замын систем, дохиоллын төхөөрөмж, мэдээлэл, холбооны систем, цахилгаан хангамжийн систем, контактын систем, төмөр замын аюулгүйн төхөөрөмжүүд, аюултай материалтай харьцах байгууламж, гэрэлтүүлгийн систем, ус зайлуулах систем болон ослын үеийн төлөвлөгөө тус тус багтана.

-Станцын байгууламжууд: Энэ нь гадна зорчигчид хүлээх танхим, орох, гарах хаалга, тасалбар түгээх болон зорчигчийн хяналтын хэсэг, урсдаг шат ба лифт, инженерийн шугам сүлжээ, үйлчилгээний хэсэг, галын аюулгүй байдлын систем, аюулгүй байдал, хяналтын систем зэргээс бүрдэнэ.

-Цахилгаан механикийн тоног төхөөрөмж: Үүнд агааржуулагч, агааржуулалт, лифт, урсдаг шат, гал унтраах систем, ус зайлуулах систем зэрэг зайлшгүй шаардлагатай системийг зохион бүтээх, нийлүүлэх, суурилуулах ажил орно.

-Депогийн байгууламжууд /шаардлагатай тохиолдолд/: Автомат хяналтын байгууламжууд, хөдлөх бүрэлдэхүүн угаах байгууламжууд, тулгуурын замын бүлгүүд, хяналтын цехүүд, дугуйны токарийн байгууламжууд, их засвар үйлчилгээний цехүүд, туршилтын замууд, захиргааны болон “ОСС” Метроны үйл ажиллагааны удирдлагын төв, сэлбэгийн агуулахууд болон бусад депогийн үйл ажиллагаатай холбоотой байгууламжууд багтана.

(б) Төмөр замын систем:

Энэхүү бүрэлдэхүүн хэсэгт метроны үндсэн ажил болох төмөр замын системийн нарийвчилсан зураг төсөл, ханган нийлүүлэлтийн хэрэгжилт багтана. Үүнд:

- **Хөдлөх бүрэлдэхүүн:** Үүнд вагон, хөдлөх бүрэлдэхүүн, орох хаалга, холбогч, зүтгүүрийн мотор, тоормосны систем, HVAC систем, өргөн нэвтрүүлгийн төхөөрөмж, CCTV систем, галт тэрэгний удирдлага, хяналтын систем болон бусад холбогдох бүрэлдэхүүн хэсгүүд орно.

¹ Төслийн техник, эдийн засгийн үндэслэл дахин шинэчлэгдэж байгаа тул тус баримт бичигт тодорхойлсон ерөнхий шаардлага нь үүгээр хязгаарлагдахгүй болно.

- **Галт тэрэгний хяналтын систем:** Галт тэрэгний автомат хамгаалалт, галт тэрэгний автомат ажиллагаа, галт тэрэгний автомат удирдлага, холбоонд суурилсан галт тэрэгний удирдлагын системийг хэрэгжүүлэх.
- **Үйл ажиллагааны хяналтын төв:** Үүнд галт тэрэгний удирдлагын төв, удирдлагад дэмжлэг үзүүлэх компьютер, том дэлгэцийн самбар, LAN төхөөрөмж, тасралтгүй цахилгаан хангамж, хананд суурилуулсан хянах болон холбогдох бусад тоног төхөөрөмж орно.
- **Харилцаа холбоо болон дохиоллын систем:** Дижитал дамжуулах төхөөрөмж, галт тэрэгний радио систем, гэрлэн дохиоллын систем, удирдах утасны төхөөрөмж, суудлын автомашиныг хянах систем болон шаардлагатай бусад холбоо харилцааны дэд бүтцийг багтаасан бүрэлдэхүүн хэсэг багтана.
- **Тасалбар хураах систем:** Үүнд төв компьютер, ашиглалтын ажлын станцууд, үндсэн засвар үйлчилгээний ажлын станцууд, станцын удирдлагын компьютерууд болон тасалбар хураах нэгдсэн системийн бусад бүрэлдэхүүн хэсгүүд орно.
- **Цахилгаан ба эрчим хүч:** Энд өндөр хүчдэлийн хуваарилах төхөөрөмж, шулуутгагч трансформатор ба шулуутгагч, цахилгаан кабель, дэд станц, зүтгүүрийн эрчим хүчний системийн бусад элементүүд орно.
- **Зорчигчдын хүлээлгийн тавцан дээрх хамгаалалтын хана, хаалга:** Үүнд: бүрэн битүүмжилсэн төрөл, хагас битүүмжилсэн төрөл, хашлага хэлбэрийн платформ дэлгэцтэй хаалганууд багтана.
- **Төмөр замын ажил:** Төмөр замын дэр модны зохион байгуулалт, бэхэлгээний угсралт, төмөр зам суурилуулах, унтраалга суурилуулах, замын хэмжилт болон замтай холбоотой бусад ажил багтана.
- **Засвар үйлчилгээний байгууламжууд:** Үүнд кран, автомат цэвэрлэгч, өргөгч, агаар компрессор, гагнуурын машин, шат дамжуургын машин, өрмийн машин, токарь болон бусад багаж хэрэгслээр хангах болон засвар, үйлчилгээний үр ашигтай үйл ажиллагаа багтана.

5. Тендер шалгаруулалтын арга, үе шат

Энэхүү төслийн тендер нь олон улсын түвшинд хамгийн чадварлаг, туршлагатай аж ахуйн нэгжүүд эсвэл тэдгээрийн түншлэлийг татан оролцуулах зорилготой 2 үе шат бүхий тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулагдана. Энэхүү аргачлалаар оролцогчдын туршлага, тэдгээрийн тэдний ирүүлсэн санал шийдлийг харгалзан үзэх бөгөөд энэхүү чухал дэд бүтцийн төсөлд хамгийн тохиромжтой түншийг сонгоно.

Нэгдүгээр үе шат: Сонирхлоо илэрхийлэх хүсэлт

Эхний үе шат нь ижил төстэй томоохон хэмжээний дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх чадвартай нь батлагдсан тохирох оролцогчдыг тодорхойлж, энэ талаар тэдэнд мэдээлэл хүргүүлэхэд чиглэгдэнэ.

Сонирхлоо илэрхийлэх тухай:

Тендер шалгаруулалтад оролцогч этгээд дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn порталаас авах боломжтой. <https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1726456870665>

Сонирхлоо илэрхийлэх хүсэлтийг харгалзан, үнэлэх:

Урьдчилан тодорхойлсон шалгуурын дагуу Хүсэлт гаргагчаас ирүүлсэн материалыг сайтар үнэлэхдээ дараах үндсэн шалгуурыг харгалзан үзнэ. Үүнд:

- **Техникийн мэдлэг:** Метроны зураг төсөл, барилга угсралт, хонгил, төмөр замын системийг нэгтгэх болон бусад холбогдох техникийн чиглэлээр туршлагаа тодорхойлсон байна.
- **Санхүүгийн чадавх:** Ийм хэмжээний төслийг хэрэгжүүлэх санхүүгийн тогтвортой байдал, нөөцийн баталгааг гаргана.
- **Холбогдох туршлага:** Харьцуулж болохуйц дэд бүтцийн төслүүдийг ижил төстэй нөхцөлд амжилттай хэрэгжүүлж байсан туршлагатай байна.

Сонирхлоо илэрхийлэх хүсэлтийн үнэлгээний дараа шаардлага хангасан нэр дэвшигчдийг дараагийн шатны тендер шалгаруултад урина.

Хоёрдугаар үе шат: Санал ирүүлэх болон тендерийн үнэлгээ

Нэгдүгээр шатны шаардлага хангасан оролцогчдыг техникийн болон санхүүгийн дэлгэрэнгүй санал өгөхийг шаардсан тендерийн саналын шатанд оролцохыг урьна.

Тендер шалгаруулалтын хоёрдугаар шатад санал ирүүлэх

Оролцогчийн өгөх саналд тендерт оролцогчийн санал болгож буй шийдэл, аргачлал, багийн бүрэлдэхүүн, холбогдох итгэмжлэл, үнийн саналыг нарийвчлан тусгах шаардлагатай.

Техникийн нарийвчилсан тодорхойлолт ба ажлын даалгавар:

Үүнд дараах зүйлс багтана:

- **Техникийн нарийвчилсан даалгавар:** Төслийн бүрэлдэхүүн хэсэг бүрийн шаардлага, үр дүнгийн талаар тодорхой тусгасан байна.
- **Цогц ажлын даалгавар:** Тендерт шалгарсан оролцогчийн ажлын цар хүрээ, үүрэг хариуцлага, гүйцэтгэлийн үр дүнг тодорхойлсон байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээ:

Ирүүлсэн саналыг техникийн болон санхүүгийн иж бүрэн шалгуурт үндэслэн нарийвчилсан үнэлгээ хийх ажил явагдана. Төслийн шаардлагад нийцсэн, өрсөлдөөний үнийн санал ирүүлсэн, техникийн үндэслэлтэй санал шийдлийг хүргүүлсэн оролцогчийг шалгаруулж, гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлж, хэлэлцээрт урина.

ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:

Төсөл хэрэгжих хугацаатай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг сонирхогч талууд төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудаснаас лавлана уу. (өөрөөр хэлбэл техникийн үзүүлэлтүүд, ажлын даалгавар, нэмэлт тодруулга зэрэг холбогдох бүх баримт бичгийг төрийн худалдан авах ажиллагааны порталаас авах боломжтой. [Link](#))

ХУУЛЬ ЁСНЫ ДАГУУ ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү тендер шалгаруулалтын нэгдүгээр шатанд ирүүлсэн санал шийдэл болон бусад баримт бичигт тусгагдсан өгөгдсөн мэдээлэл нь зөвхөн мэдээллийн мэдээлэл өгөх зорилгоор бэлтгэгдсэн бөгөөд заавал биелүүлэх санал эсвэл гэрээ биш болно.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь Духуа инженеринг консалтинг болон түүний түншлэлтэй харилцан зөвшилцсөний үндсэн дээр ямар ч үед, бие даан дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- Энэхүү нэгдүгээр үе шатанд мэдүүлэг хүлээн авах үйл ажиллагааг бүхэлд нь цуцлах;
- Энэхүү нэгдүгээр үе шатанд мэдүүлэг хүлээн авах үйл ажиллагааны эцсийн хугацааг сунгах;
- 2013 онд эхлүүлсэн “Улаанбаатар метро” төслийн ТЭЗҮ-г дахин шинэчлэн боловсруулж, тус тайлангийн эцсийн дүгнэлт, зөвлөмж дээр үндэслэн энэхүү баримт бичигт заасан төслийн ажлын хэрэгжилтийн цаг хугацаа болон төслийн нийт төсөвт өртөгт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан эцэслэн шийдвэрлэнэ.

Төслийн бүрдэл хэсэг бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл болон тусгай шаардлагуудыг Духуа инженеринг консалтингийн эцсийн ТЭЗҮ-ийн тайланд тусгах болно.

Техникийн үзүүлэлтүүдийн дэлгэрэнгүй тайлбарыг Монгол Улсын Засгийн газрын Худалдан авах ажиллагааны портал дээрээс авах боломжтой. Та бүхэн линкээр орж үзнэ үү. <https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1726456870665>